

ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН

ТОГТООЛ

2022 оны 3 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 06

Баянтөхөм

**ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ  
ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ**

Сумын Засаг дарга Т.Түвшинбатын өргөн барьсан Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай санал, шийдвэрийн төсөл, мэдээллийг хэлэлцээд, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.5, 41.6, 41.8 дахь заалт, Татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.21, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгүүдийг тус тус үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

- 1.Сумын нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоож хавсралтаар баталсугай.
- 2.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тухайн оны сар бүр өрх, аж ахуйн нэгж байгууллагаас хурааж, орон нутгийн орлогод төвлөрүүлэхэд онцгой анхаарч шат дараалалтай арга хэмжээг авч, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг дарга (Т.Түвшинбат)-д даалгасугай.
- 3.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.
- 4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн "Хог хаягдлын журам батлах тухай" 55 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА С.ЭНХТҮВШИН